



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН САРЫН МЭДЭЭНИЙ ТОЙМ

2011 оны
1-р сар

Нийгмийн даатгалын санд 2011 оны 1-р сард **29.6 тэрбум** төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг **123.3 хувиар** биелүүлсэн байна. Даатгалын сангаас давхардсан тоогоор **407.7 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж үйлчилгээний зардалд нийт 59.1 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 31.8 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын санд шилжүүлэв.**

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО

Нийгмийн даатгалын таван төрлийн санд 2011 оны 1-р сард 29.6 тэрбум төгрөгийн шимтгэл төвлөрүүлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.8 тэрбум төгрөгөөр өсчээ.

Жилийн нийт төлөвлөсөн орлогын 6.8 хувийг 1-р сарын байдлаар оруулаад байгаа бөгөөд ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлого дараахь байдлаар сангуудад хуваарилсан байна. Үүнд :

- Тэтгэврийн даатгалын санд 62.7 % буюу 18.6 тэрбум төгрөг;
- Тэтгэмжийн даатгалын санд 4,5 % буюу 1.3 тэрбум төгрөг;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 7.4 % буюу 2.2 тэрбум төгрөг;
- Ажилгүйдлийн даатгалын санд 4.3 % буюу 1.3 тэрбум төгрөг;
- Эрүүл мэндийн даатгалын санд 21.2 % буюу 6.3 тэрбум төгрөг.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА

2010 оны 1-р сард нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 59.1 тэрбум төгрөг зарцуулжээ. Жилийн нийт төлөвлөсөн зардлын 9.8 хувь буюу 59.1 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.


Тэтгэврийн даатгалын сан

Тухайн сард тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 302.9 мянга орчим иргэдийн тэтгэвэрт 49.8 тэрбум төгрөг зарцуулжээ. Нийт зардлын 73.7 хувь буюу 36.7 тэрбум төгрөгийг өндөр насны тэтгэвэрт зарцуулжээ.

Тэтгэмжийн даатгалын сан

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмжид 1.4

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого /тэрбум төгрөгөөр/




■ Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого
● Жилийн нийт орлогод тухайн сарын орлогын эзлэх хувь


Нийгмийн даатгалын сангийн зарлага /тэрбум төгрөгөөр/



Тэтгэвэрт зарцуулсан хөрөнгө /тэрбум төгрөг/



Тэтгэмжийн даатгалын сангийн зардал /сая төгрөгөөр/



тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 78.0 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Нийт зардлын 50.3 хувийг жирэмсний болон амаржсаны тэтгэмжид зарцуулжээ.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан

Тус сангаас 1-р сард 6.3 мянган тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 1.7 тэрбум төгрөг, 0.1 мянга гаруй хүнд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувилалд ирж, буцах зардал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд нийт 32.6 сая төгрөгийг тус тус зарцуулав.

Ажилгүйдлийн даатгалын сан

2011 оны 1 сарын мэдээгээр ажилгүйдлийн даатгалын сангаас 747.4 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын тэтгэмж, сургалтын зардалд зарцуулсан нь 2010 оны мөн үетэй харьцуулахад 156.9 хувиар буюу 270.9 сая төгрөгөөр нэмэгджээ.

Эрүүл мэндийн даатгалын сан

Тухайн сард эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардалд 5.4 тэрбум төгрөг зарцуулсан байна. Нийт зардлын 96.5 хувийг эмнэлгийн тусламж үйлчилгээний зардалд, 2.3 хувийг рашаан сувилалд, 1.2 хувийг эмийн үнийн хөнгөлөлтөд тус тус зарцуулав.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага оны эхнээс 0.9 тэрбум төгрөгөөр өсч 14.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт шимтгэлийн авлагын 91.4 хувийг аж ахуйн нэгж байгууллагуудын авлага эзэлж байна.

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардал

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын 1 дүгээр сарын мэдээгээр нийт 1128.6 сая төгрөг төлөвлөснөөс 902.7 сая төгрөг зарцуулж, 226.0 сая төгрөг хэмнэгдсэн байна. Уг зардал нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 259.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

ҮОМШӨ-ний даатгалын сангийн зардал

/сая төгрөгөөр/

Зардлын зүйл	2010.1 сар	2011.1 сар	Зөрүү	
			Тоогоор	Хувиар
Тэтгэвэр	1134.8	1731.3	596.5	152.6
Тэтгэмж, төлбөр	19.1	32.6	13.5	170.7
Нийт	1153.9	1763.9	610.1	152.9

Ажилгүйдлийн даатгалын сангийн зардал

/сая төгрөгөөр/

Зардлын зүйл	2010.1 сар	2011.1 сар	Зөрүү	
			Тоогоор	Хувиар
Ажилгүйдлийн тэтгэмж	472.5	747.2	274.7	158.1
Сургалтын зардал	4.0	0.2	-3.8	5.0
Нийт	476.5	747.4	270.9	156.9

Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал

/сая төгрөгөөр/

Зардлын зүйл	2010.1 сар	2011.1 сар	Зөрүү	
			Тоогоор	Хувиар
Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	3862.5	5173.0	1310.5	133.9
Эмийн үнийн хөнгөлөлт	58.8	66.8	8.0	113.6
Рашаан сувилал	30.0	120.6	90.6	402.0
Нийт	3951.3	5360.4	1409.1	135.7

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага /тэрбум төгрөгөөр/



Үйл ажиллагааны зардал

(сая.төгрөгөөр)

Үзүүлэлт	2010.1 сар	2011.1 сар	Өөрчлөлт	
			Тоогоор	Хувиар
Цалингийн сан, нийгмийн даатгалын шимтгэл	478.4	779.4	301.0	162.9%
Бараа үйлчилгээний бусад зардал	164.5	123.3	-41.2	75.0%
Урсгал зардлын дүн	642.9	902.7	259.8	140.4%